УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ

2025 оны 06 дугаар сарын 25

| № | Д/д | Зорилго | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж | Суурь түвшин (2023) | Зорилтот түвшин | Арга хэмжээний хэрэгжилт | Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь | Батлагдсан төсөв /сая төгрөг/ | Батлагдсан эх үүсвэр | Хариуцах газар | ХШҮ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 10 | 1.1.2. Эрчим хүчээр хангагдсан хот | 1.1.2.4.Хог шатаах аргаар эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэрийн төслийг дэмжинэ. | 10 | 15-20 МВт-ын хүчин чадалтай хог шатаах үйлдвэр байгуулах | Төслийн гүйцэтгэл, хувь | - | 10 | Нийслэлийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/238 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтаар батлагдсан ажлын хэсгээс "Хог шатааж, эрчим хүч үйлдвэрлэх" төсөлд Наанова грийн энержи Монголиа ХХК, Эко Юу Би ХХК, Сычуань Эрчим хүчний хөрөнгө оруулалт ХХК, Шанхай ЭсЮЭс Энвайрмент ХХК-с ирүүлсэн саналыг "Түншлэлийн төслийн урьдчилсан үнэлгээ, бүрэн шинжилгээ хийх" журамд заасан нөхцөл, шаардлагыг хангасан гэж дүгнэсэн. Бүрэн шинжилгээний баг дээрх дөрвөн саналаас "Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль"-ийн 18.2-т заасан тусгай шаардлага дээр үндэслэн Сычуань Эрчим хүчний хөрөнгө оруулалт ХХК-ний ирүүлсэн саналыг бүрэн шинжилгээнд хөгжүүлэхээр санал нэгдсэн. Улаанбаатар түншлэл төв ХХК нь ШУТИС, Эрчим Хүчний Их Сургууль, Дулааны Техник, Үйлдвэрлэлийн Экологийн Хүрээлэнтэй хамтран хог шатааж эрчим хүч гаргах үйлдвэрийн ТЭЗҮ-г боловсруулж мэргэжлийн зөвлөлийн хуралд танилцуулж батлуулсан. Ажлын хэсгийн зүгээс бүрэн шинжилгээний ажлыг НИТХ-д танилцуулж дууссан бөгөөд дараагийн сонгон шалгаруулах ажлын хэсгийн эрхийг хурлаас олгосон. | | - | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ | | 30 |
| 2 | 18 | | 1.1.2.11.Гэр хорооллын айл өрхүүдийн дулаан алдагдлыг бууруулж, эрчим хүчний хэмнэлт бий болгох дулаалгын төслийг хэрэгжүүлнэ. | 21 | Гэр хорооллын айл өрхийн дулаан хангамжийг бусад эх үүсвэрт үе шаттай шилжүүлэх | Төсөлд хамрагдах айл өрх, өссөн дүнгээр тоо | 445 | 8,000 | 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн эрх шилжүүлэх А/164 дүгээр захирамжид тусгагдсан "Шингэрүүлсэн нефтийн хийн түлшээр (LPG) 30-аас доошгүй айл өрхийг бие даасан байдлаар холбох хангах ажил"-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаагаар Таван толгой түлш ХХК зохион байгуулсан. Зөвлөмжийн дагуу Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба нь 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдөр "Рутан" ХХК -тай гэрээ байгуулан ажиллаж байна. | 20 | 2,880.0 | Улсын болон орон нутгийн төсөв | ХБХСГ УБЗАА | 20 |
| 3 | 24 | | 1.1.3.2.Цэвэрлэх байгууламжийн тархмал дэд төвүүдийг шинээр байгуулах, бие даасан, бага оврын ариун цэврийн байгууламжийн хэрэглээг бодлогоор дэмжих замаар нүхэн жорлонгийн тоог 2 дахин багасгаж, хөрсний бохирдлыг бууруулна. | 27 | Бага хүчин чадлын цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл хэрэгжүүлэх | Загвар төсөл, тоо | - | - | СХД-ийн 40-р хороонд зөөврийн бохир усны Урьдчилсан цэвэрлэх байгууламжийг барихаар 2025 оны 04 дүгээр сараас эхэлсэн боловч иргэдийн эсэргүүцлээс шалтгаалж, байршил өөрчлөгдсөн. СХД-ийн 6-р хороонд урьдчилсан цэвэрлэх байгууламжийг барих газрыг Ус сувгийн удирах газар ОНӨААТҮГ-ын нэр дээр 2025 оны 05 дугаар сард шилжүүлэн авсан. Байгууламжийн архитектур төлөвлөлтийн даалгавар шинэчлүүлэх хүсэлтийг Хот байгуулалт, хотын стандартын газарт албан хүсэлтийг хүргүүлсэн. | 30 | - | БНСУ-ын буцалтгүй тусламж | УБЗАА | 30 |
| 4 | 25 | | | 28 | Бага хүч чадлын цэвэрлэх байгууламжийн усгүйжүүлсэн, хатаасан лагийг булшлах загвар төсөл хэрэгжүүлэх | Загвар төсөл, тоо | - | - | АНУ-ын Мянганы Сорилтын сангийн буцалтгүй тусламжаар "Улаанбаатар хотын лагийн урт хугацааны төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээ"-ний ажлыг Хайзен (Hazen) ХХК 2024 оны 08 дугаар сараас боловсруулж байгаа бөгөөд Захирагчийн ажлын албанаас холбогдох судалгааны материалаар хангах, тодорхой шийдлийг оруулж хамтран ажиллаж байна. Лагийн урт хугацааны төлөвлөгөөнд тодорхой загвар төслүүдийг тусган ажиллаж байгаа ба зөвлөх үйлчилгээ 2025 оны 08 дугаар сард дууссна. | 50 | - | АНУ-ын Мянганы Сорилтын корпорацийн буцалтгүй тусламж | УБЗАА | 50 |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | 26 | | | 29 | Зөөврийн бохир усанд урьдчилсан цэвэрлэгээ хийх зориулалт бүхий бохир усны юулэх станцыг барьж байгуулах | Барьсан бохир усны юулэх станц, өссөн дүнгээр | - | 1 | СХД-ийн 40-р хороонд зөөврийн бохир усны Урьдчилсан цэвэрлэх байгууламжийг барихаар 2025 оны 04 дүгээр сараас эхэлсэн боловч иргэдийн эсэргүүцлээс шалтгаалж, байршил өөрчлөгдсөн. СХД-ийн 6-р хороонд урьдчилсан цэвэрлэх байгууламжийг барих газрыг Ус сувгийн удирах газар ОНӨААТҮГ-ын нэр дээр 2025 оны 05 дугаар сард шилжүүлэн авсан. Байгууламжийн архитектур төлөвлөлтийн даалгавар шинэчлүүлэх хүсэлтийг Хот байгуулалт, хотын стандартын газарт албан хүсэлтийг хүргүүлсэн. | 30 | 3,000.0 | БНСУ-ын буцалтгүй тусламж | НЗДТГ-ХСТХХТ, УБЗАА | 20. |
| 6 | 28 | 1.1.3. Гэр хорооллын дахин төлөвлөлт, орон сууцжуулалт | 1.1.3.4.Хот, суурин газрыг дахин төлөвлөн хөгжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ. | 32 | Нийслэл, орон нутагт хот дахин төлөвлөлтийн төслүүдийг хэрэгжүүлж, инженерийн шугам сүлжээг төлөвлөн барих | Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, тоо | 18 | 3 | БЗД-ийн 8, 12, 16-р хороо, орон сууцны 14-р хорооллын дахин төлөвлөлтийн талбайд баригдах орон сууцны хорооллын гадна цэвэр, бохир усны шугам сүлжээний ажлын зураг зөвшилцсөн. | 50 | 18,000.0 | Улсын төсөв | УБЗАА, НХБХСГ | 30 |
| 7 | 33 | | 1.1.3.6.Улаанбаатар хотын инженерийн дэд бүтцийг шинээр барьж, өргөтгөн шинэчилж хүчин чадлыг нэмэгдүүлнэ. | 37 | Хотын ус хангамжийн усан сан, дамжуулах шугам сүлжээг шинээр болон өргөтгөн барьж, ашиглалтад оруулах | Арга хэмжээний хэрэгжилт, хувь | • | 10 | Инженерийн хангамжийн байгууллага, харьяа газар, дүүргүүд 2025 онд инженерийн дэд бүтцийн чиглэлээр 142 төсөл, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байгаа бөгөөд 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар нийт ажлын гүйцэтгэл 30.5 хувьтай байна. Үүний дотор Улаанбаатар хотын төвлөрсөн дулааны хангамжийн гол шугам, тоноглолд 2025 оны зуны их урсгал засварын ажлын төлөвлөгөөгөөр 32 байршилд нийт 13.5 км дулааны гол шугам сүлжээ, орон сууцны хорооллын доторхи 19 байршилд 15 км шугам сүлжээг шинэчлэн солих, авто замын бороосны ус зайлуулах шугам угсралтын ажлын хүрээнд 6 байршилд 15 км шугам угсралтын ажил хийгдэж байна. Мөн ХУД-ийн 11-р хороо, Зайсангийн амьг ус хангамжийн төвлөрсөн системд холбох цэвэр усны гол шугам сүлжээний угсралтын ажил 90%, усан санг, насос станцын барилга угсралт 70%-тай явагдаж байна. | 30 | 55,500.0 | Улсын болон орон нутгийн төсөв, Гадаадын зээл, тусламж | УБЗАА, НХБХСГ | 30 |
| 8 | 37 | | 1.1.3.8.Эрчим хүчний хэмнэлттэй бий болгох, нийслэлийн орон сууцны дулаан алдагдлыг бууруулах зорилгоор 1 удаа орон сууцны дулаалгын ажлыг хийнэ. | 42 | Угсармал орон сууцыг дулаалгын төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх | Арга хэмжээний хэрэгжилт, хувь | 40 | 60 | Нийслэлийн 2025 оны төсөвт "Угсармал орон сууцны дулаалгын төсөл"-д 9,8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг батлуулж, Нийслэлийн Засаг даргын А/590 дугаар захирамжаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах эрхийг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд даалгасан. Батлагдсан төсвөөр 10 байршилд 19 блок барилгыг дулаалах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар тендерийг 2025 оны 05 дугаар сард зарлаад байна. Дулаалагдахаар төлөвлөгдсөн байршлуудад Баянзүрх дүүргийн 8 дугаар хорооны 1, 2 дугаар байрын 4 блок, 40 дүгээр хорооны 2 дугаар байрны 2 блок, Сонгинохайрхан дүүргийн 6 дугаар хорооны 28, 29 дүгээр байр 12 давхар 2 блок,15 дугаар хорооны 23-6, 23-7, 23-8, 23-9, 23-10 блок, дугаар байрны 9 давхар 5 блок, Баянгол дүүргийн 15, 19, 14 дүгээр хорооны 20, 28, 55 дугаар байр 5 блок барилга багтаж байна. | 50 | 49,820.0 | Улсын болон орон нутгийн төсөв | УБЗАА | 30 |
| 9 | 39 | | 1.1.4.1.Хууль бусаар олгосон газрыг нийтийн эзэмшлийн газар болгож, уг газарт ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн барьж, хотын иргэн оршин суугаа газраасаа 400 метр дотор амарч, тухлах нөхцөлийг бүрдүүлнэ. | 44 | Нийтийн эдэлбэр газрын байршлыг тогтоож, бүртгэлжүүлэх, хамгаалах ажлыг зохион байгуулах | Нийтийн эдэлбэр газарт бүртгэсэн байршил, өссөн дүнгээр | 136 | 141 | Дүүргийн төсвийн хөрөнгөөр Баянзүрх дүүрэг 1 байршилд 5100м2 талбай бүхий цэцэрлэгт хүрээлэн 348 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, Сонгинохайрхан, Налайх дүүрэг 3290м2 талбайд 289 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, Хан-Уул, Налайх дүүрэг 8.2га талбайд 3 байршилд 346 сая төсөв өртөгтэй ажлуудыг зохион байгуулахаар худалдан авах ажиллагаа явагдаж байна. | | 983,100,000.0 | Дүүргийн төсөв | УБЗАА НГЗБА Дүүргүүд | 30 |
| 10 | 40 | | | 45 | Чөлөөлсөн байршилд иргэд амарч зугаалах, спортоор хичээллэх ая тухтай орчныг бүрдүүлж, тохижуулах | Чөлөөлсөн газарт ногоон байгууламж байгуулсан хэмжээ, м.кв | 89 | 30 | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 24/33 дугаар тогтоолоор нийслэлийн төсөвт граж, хайс хашлага буулгаж, чөлөөлсөн газар дээрх нөхөн сэргээлт хийх, явган зам, ногоон байгууламжийн барилгын ажил, зөвлөх үйлчилгээнд 1,600.0 сая төгрөг суулгасан. | | 6,000.0 | Улсын болон орон нутгийн төсөв | УБЗАА Дүүргүүд | 0 |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 11 | 49 | 1.1.4. Ногоон-ухаалаг хот | 1.1.4.6.Туул, Сэлбэ, Улиастай, Нарангийн голын эргийн хамгаалалтын 30 км далан болон ус зайлуулах 100 км сувгийг шинээр барьж, дөрвөн байршилд усан сан, хөв, цөөрөм байгуулж, хот доторх гол, горхины урсцад тохируулга хийдэг болно. | 55 | Голууд дээр үерийн хамгаалалтын далан, тохируулгатай усан санг барьж ашиглалтад оруулах | Далангийн нийт урт, км | 51.6 | 58.6 | 1. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 24/33 дугаар тогтоолоор хөрөнгө батлагдсан "Сэлбэ сэргэлт" төслийн Сэлбэ-Дунд голын үерийн хамгаалалтын барилга байгууламжийн угсралт (БЗД, 43 дугаар хороо, СБД, 1-р хороо, I ээлж ПК18+00-ПК25+33) ажлыг "Билгүүн монгол констракшн" ХХК гүйцэтгэж, 2025 оны 06 дугаар сарын байдлаар түшиц ханын угсралтын ажил 90 хувьтай байна.<br>2. Арцат, Нүхт, Морь барьдагийн ам, уяачдын хотхоны үерийн хамгаалалтын барилга байгууламжийн (ХУД, 4,5,6,7,8 дугаар хороо)-д ажлыг Монгол Менежмент төв ХХК гэрээ байгуулсан бөгөөд 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр зураг зохиогч, гүйцэтгэгч байгууллагатай хамтран 5 шугамын трассын дагуу талбайн үзлэг хийсэн. Үзлэгээр ХУС-1-д 16 айлын газар чөлөөлөх, ХУС-2 трассын дагуу бохир усны шугамын давхцсаныг шийдвэрлэх, ХУС-3 трассад Яармагийн шинэ бохир усны шугамын ажил угсрагдсан, ХУС-4-ын трассад 10 айл газар чөлөөлөлт хийх, Шинэ хотхон орон сууц баригдсан зай талбай бага, ХУС-5-ийн трассад 3 айлын газар чөлөөлөлт хийх шаардлагатай байна. Мөн тус зураг төсөл 2024 онд боловсруулагдсан бөгөөд 2025 онд уг зураг төслөөр барилга угсралтын ажил эхлэх боломжгүй. Шинээр хийгдсэн, одоо төлөвлөгдөж буй инженерийн шугам сүлжээтэй зураг төсвийг уялдуулан шинээр боловсруулах шаардлагатай тул гэрээг цуцлахаар шийдвэрлэсэн.<br>3. Чингэлтэй дүүргийн Үерийн хамгаалалтын барилга байгууламжийн ажил (ЧД, 7, 10, 12, 16, 17 хороо, I ээлж I, II суваг)-ын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг 2025 оны 05 дугаар сард зарлаад байна.<br>4.Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 24/33 дугаар тогтоолоор нийслэлийн төсөвт Эрдэнэтолгой, УС-15 орчмын үерийн | 50 | 27,000.0 | Нийслэлийн төсөв | УБЗАА | 50 |
| 12 | 50 | | | 56 | Ус зайлуулах сувгийг барьж ашиглалтад оруулах | Сувгийн нийт урт, км | 107.6 | 132.6 | Үерийн далан суваг, хөрсний усны чиглэлээр: Үерийн ус зайлуулах далан суваг, шугам сүлжээ, худаг, насос станцын засвар, нөхөн сэргээлт, цэвэрлэгээнийн ажил 41,6 хувийн гүйцэтгэлтэй хийгдэж байна. Мөн Геодези, усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ нь авто замын борооны ус зайлуулах шугам угсралтын ажлын хүрээнд 6 байршилд 15 км шугам угсралтын ажлыг хийж байна. | 50 | 15,000.0 | Нийслэлийн төсөв | УБЗАА, НХБХСГ | 50 |
| 13 | 51 | | | 57 | Тохижилттой хөв, цөөрөм барьж ашиглалтад оруулах | Хөв, цөөрөм барих ажлын зураг төсөл боловсруулалтын хэрэгжилт, хувь | - | 100 | 2019-2023 оны хооронд нийслэлийн нутаг дэвсгэрт 4 хөв цөөрөм байгуулсан. 3 хөв цөөрмийг нь нийслэлийн төсвийн хөрөнгөөр, 1 хөвийг аж ахуй нэгж байгууллагын хөрөнгөөр барьж байгуулсан. 2024 онд Хан-Уул дүүргийн 14-р хорооны нутаг дэвсгэрт 1 хөв байгуулахаар ажилласан боловч гүйцэтгэгч орж ирээгүй болно. | 50 | 200.0 | Орон нутгийн төсөв | УБЗАА, НБОГ | 20 |
| 14 | 52 | | 1.1.4.7."Туул усан цогцолбор төсөл"-ийг хэрэгжүүлж, үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлж, үндны ус, ахуйн усан хангамжийг нэмэгдүүлнэ. | 58 | "Туул усан цогцолбор төсөл"-ийг хэрэгжүүлэх | Төслийн гүйцэтгэл, хувь | 5 | 10 | НИТХ-ын 2025 оны 25/01 дүгээр тогтоолоор Нийслэл Улаанбаатар хотод Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн жагсаалтад 2026 оноос хэрэгжүүлж эхлэхээр тусгагдсан. Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах хөрөнгө Нийслэлийн төсөвт тусгагдаагүй. Энэтхэг улсын KPIL ХХК нь "Туул усан цогцолбор" төслийн урьдчилсан ТЭЗҮ, судалгааны ажлыг Усны газрын захиалгаар гүйцэтгэж, 2025 оны 06 дугаар сард эцсийн тайлан өгөх хүсэлтээ ирүүлээд байна. | 50 | 48,052.0 | Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж | УБЗАА | 50 |
| 15 | 91 | 1.4.2.Орон нутгийн хөгжлийн нийтлэг зорилт | 1.4.2.6.Хот, суурин газруудын хүн амын ундны цэвэр усны шугамыг ээс шугамаар сольж, ундны усны чанар, аюулгүй байдлыг хангана. | 160 | Хот, суурин газруудын хүн амын ундны цэвэр усны шугамыг ээс шугамаар солих судалгаа хийж, загвар төсөл хэрэгжүүлэх | Тухайн жилийн арга хэмжээний хэрэгжилт, хувь | * | 100 (Судалгааны ажил) | Хөрөнгө тусгагдаагүй. | | 50.0 | Бусад эх үүсвэр | УБЗАА, ХБХСГ | |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 16 | 131 | 2.4.3.Нийтийн ажахуй, инженерийн дэд бүтэц | 2.4.3.4.Орон сууц, нийтийн аж ахуйн инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийг өргөтгөн шинэчлэх, дэвшилтэт техник, тоног төхөөрөмж суурилуулах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, ашиглалтын түвшинийг сайжруулна. | 461 | Улаанбаатар хотын ус хангамжийн баруун эх үүсвэрийг шинээр барьж, ашиглалтад оруулах | Төслийн гүйцэтгэл, хувь | 53,81 | 90 | Ус хангамжийн Баруун эх үүсвэрийн төслийн хэрэгжилт 2025 оны 06 дугаар сарын байдлаар 88 хувийн хэрэгжилттэй байна. Төслийн хүрээнд Доод эх үүсвэрийн ус гүн цэвэршүүлэх байгууламжийн бүтээн байгуулалт 98.3, Биокомбинат, Шувуун фабрик орчмын гүний 30 худаг, 55 км ус дамжуулах шугам сүлжээний суурилуулалт 81.8% байгаа бөгөөд тоног төхөөрөмж, туршилт тохируулгын ажилд Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын инженер, техникийн ажилтнууд томилогдон дадлагажин ажиллаж байна. | 88 | - | АНУ-ын Мянганы Сорилтын корпорацийн буцалтгүй тусламж | УБЗАА, УСУГ | 90 |
| 17 | 132 | | 2.4.3.5.Хот, суурин газарт үерийн эрсдэлийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээг хийж, инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөө боловсруулж үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 465 | 21 аймаг болон эрсдэлтэй хот, суурин газарт үерийн эрсдэлийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийх | Эрсдэлийн үнэлгээний тайлангийн хэрэгжилт, хувь | - | - | Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2025 оны 02 дугаар сарын 19-ны А/20 дугаартай тушаалаар Нийслэлийн Онцгой байдлын газар "Улаанбаатар хотын халиа дошин, шар усны үерийн эрсдлийн ерөнхий үнэлгээ" боловсруулж байна. | 50 | - | Орон нутгийн төсөв | УБЗАА, НХБХСГ | 50 |
| 18 | 133 | | | 466 | 21 аймагт инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөө гаргаж, арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх | Төлөвлөгөөний хэрэгжилт, хувь | - | - | Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 65 дугаар тогтоолоор "Хотын инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөө" батлагдсан. Улаанбаатар хотын үерийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Дэлхийн банктай хамтран "Улаанбаатар хотын үерийн эрсдэлийг бууруулах, бохир усны шугам сүлжээний шинэчлэлийн төсөл", мөн Туул, Сэлбэ голын тохижилт, үерийн хамгаалалтын барилга байгууламж, усан сан барих төслийн техник эдийн засгийн үндэслэлийг шинэчлэн боловсруулах, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний баримт бичиг боловсруулахаар ажиллаж байна. | 50 | - | Орон нутгийн төсөв | УБЗАА, НХБХСГ | 50 |
| 19 | 134 | | 2.4.3.6.Саарал усыг дахин ашиглана. | 467 | Саарал усыг орон сууц, үйлдвэр, албан байгууллагад ашиглах загвар төсөл хэрэгжүүлэх | Загвар төсөл хэрэгжүүлсэн байршил, тоо | - | - | Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр барих ажлын хэрэгжилт 2025 оны 06 дугаар сарын байдлаар 82 хувьтай байна. Мөн хаягдал цэвэршүүлсэн ус дамжуулах 12 км шугам, Дулааны III, IY станцын шугамын өөрчлөлтийн ажлын гүйцэтгэл 78 хувьтай байна. | 82 | - | Орон нутгийн төсөв | УБЗАА, НХБХСГ | 80 |
| 20 | 135 | | 2.4.3.7.Бохирдуулагч үйлдвэр, үйлчилгээний салбарын хаягдал усны хяналтыг сайжруулна. | 468 | Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын урьдчилан цэвэрлэх байгууламж болон ахуйн бохир усны бага хүч чадлын цэвэрлэх байгууламжаас гарч байгаа хаягдал усны стандартын шаардлагыг хангуулах, хяналт шалгалт хийх | Стандартын хэрэгжилт, хувь | - | 15 | Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 53 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө"-г холбогдох бүх шатны байгууллагууд хамтран хэрэгжүүлж байна. Мөн MNS 6561:2024 стандартыг хангуулахаар 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн А/68 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулж бохирдлын түвшин ихтэй 70 үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын бохир усны гаргалгаа шугамд бохирдол бууруулах тоног төхөөрөмж, суурилуулалт, үйлдвэрүүдийн урьдчилан цэвэрлэх байгууламж угсрах, суурилуулах ажлын явц, хэвийн ажиллагаанд хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авах арга хэмжээний зөвлөмж боловсруулж зөвлөгөө мэдээлэл, шаардах хуудас өгч ажиллаж байна. MNS6561:2024 стандартын шаардлага хангуулах үүднээс 2025 оны хагас жилийн байдлаар Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-аас 540 үйлдвэр, аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийж хаягдал уснаас дээж авч лабораторийн шинжилгээ хийсэн. Нийт сорьцийн 54%-нь стандартаас хэтэрсэн үзүүлэлттэй байна. | 50 | 30.0 | Улсын төсөв | УБЗАА, НХШГ, НЭМГ, НХХААГ, НБОГ, УСУГ | 50 |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 21 | 182 | 3.4.3 Ногоон эдийн засаг, ногоон хөгжлийн загвар | 3.4.3.4.Хаягдал бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөж, шинээр барьж, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг нэмэгдүүлнэ. | 1001 | Бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих /Улаанбаатар, Дорнод, Завхан, Баян-Өлгий, Увс, Говьсүмбэр, Говь-Алтай, Ховд, Баянхонгор, УБ Багануур дүүрэг, Дархан-Уул Шарын гол, Сэлэнгэ Сайхан сум/ | Ашиглалтад орох цэвэрлэх байгууламж, тоо | • | 5 | Шинэ Төв цэвэрлэх байгууламжийн барилга бүтээцийн ажил 2025 оны 06 дугаар сарын байдлаар 98 хувьд хүрсэн бол тоног төхөөрөмж суурилуулах ажил 85 хувьтай,технологийн 35 төрлийн 55 барилга, байгууламж, инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн ажил 91 хувьтай үргэлжилж байна. Шинэ цэвэрлэх байгууламжийн техник технологийн туршилтын ажил нь 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрөөс эхэлнэ. | 91 | 259.5 сая доллар | БНХАУ-ын хөнгөлөлттэй зээл | УБЗАА, УСУГ | 90 |
| 22 | 183 | | | 1003 | Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийн лагийг хатаах, шатаах байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах, лагийн урт хугацааны менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх | Төслийн гүйцэтгэл, хувь | • | 10 | АНУ-ын Мянганы Сорилтын сангийн буцалтгүй тусламжаар "Улаанбаатар хотын лагийн урт хугацааны төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээ"-ний ажлыг Хайзен (Hazen) ХХК 2024 оны 08 дугаар сараас боловсруулж байгаа бөгөөд Захирагчийн ажлын албанаас холбогдох судалгааны материалаар хангах, тодорхой шийдлийг оруулж хамтран ажиллаж байна. Лагийн урт хугацааны төлөвлөгөөнд тодорхой загвар төслүүдийг тусган ажиллаж байгаа ба зөвлөх үйлчилгээ 2025 оны 08 дугаар сард дууснa. Шинэ Төв цэвэрлэх байгууламжийн барилга бүтээцийн ажил 2025 оны 06 дугаар сарын байдлаар 98 хувьд хүрсэн бол тоног төхөөрөмж суурилуулах ажил 85 хувьтай,технологийн 35 төрлийн 55 барилга, байгууламж, инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн ажил 91 хувьтай үргэлжилж байна. Шинэ цэвэрлэх байгууламжийн техник технологийн туршилтын ажил нь 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрөөс эхэлнэ. | 50 | 2,140.0 | АНУ-ын Мянганы Сорилтын корпорацийн буцалтгүй тусламж | НЗДТГ-ХСТХХТ, УБЗАА, УСУГ | 50 |
| 23 | 184 | | | 1004 | "Морингийн давааны цэвэрлэх байгууламжийг өргөтгөх төсөл"-ийг хэрэгжүүлэх | Төслийн гүйцэтгэл, хувь | • | 10 | 2025 оны улсын төсөвт шаардлагатай хөрөнгө тусгагдаагүй. | | 3,000.0 | Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж | УБЗАА, УСУГ | |
| 24 | 185 | | 3.4.3.5.Цэвэрлэх байгууламж, гэр хорооллын ариун цэврийн байгууламжийн лагийг байгальд ээлтэй аргаар устгах туршилтын төсөл хэрэгжүүлнэ. | 1006 | Гэр хорооллын 500 өрхийн ариун цэврийн байгууламжийн лагийг багасгах, үнэргүйжүүлэх, цэвэрлэх аргаар хөрсийг эрүүлжүүлэх туршилтын төсөл хэрэгжүүлэх | Төслийн гүйцэтгэл, хувь | • | 50 | СХД-ийн 24-р хороонд БНСУ-ын буцалтгүй тусламжаар 726 айл өрхийн ариун цэврийн байгууламжийг шинэчлэн эко ариун цэврийн байгууламжаар солих ажил 70 хувьтай хэрэгжиж байна | 70 | 5.0 сая доллар | БНСУ-ын буцалтгүй тусламж | УБЗАА | 70 |
| 25 | 201 | 4.2.4. Орон нутгийн засаглалын бие даасан байдал | | 1171 | Нийслэлийн хэмжээнд өвөрмөц дүр төрхтэй, олон зориулалт бүхий гудамж, талбайг барьж, тохижуулах | Нэмэгдүүлэх гудамж, талбайн байршил, өссөн дүнгээр | 134 | 20 | НЗД-ын 2025 оны А/560 дугаар захирамжийн хүрээнд Нийслэлийн 204 хороонд 10.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж, Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн эрүүл аюулгүй орчныг хангуулж ажиллаж байна. | 50 | • | Нийслэл | УБЗАА, дүүргүүд | 50 |
| | | | | . | | | | | | | | | | 44.34% |

ХЯНАСАН:
ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА Ц.РЭГЗЭДМАА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Ш.ЧАНЦАЛНУРМАА

НЭГТГЭСЭН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН Т.ҮҮРИЙНТУЯА